



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООХ

2017 оны 6 дугаар
сарын 7-ны өдөр

Дугаар 160

Улаанбаатар
хот


Журам батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Гадаадын арбитр болон гадаад улсын шүүхэд маргаан үүсэхээс урьдчилан сэргийлэх, маргааныг хэлэлцээний замаар шийдвэрлэх, маргаан үүссэн тохиолдолд баримтлах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Гадаад улсын хуулийн этгээдтэй гэрээ байгуулах, маргаан үүсэх болон маргааныг шийдвэрлэх шатанд энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан журмыг баримталж ажиллахыг Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга нарт болон төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой компанийн удирдлагад тус тус даалгаж, Улсын Их Хуралд ажлаа шууд тайлагнадаг байгууллагын дарга нарт зөвлөмж болгосугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат, Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт нарт үүрэг болгосугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

Хууль зүй, дотоод хэргийн сайд

С.БЯМБАЦОГТ

Засгийн газрын 2017 оны 160 дугаар
тогтоолын хавсралт

ГАДААДЫН АРБИТР БОЛОН ГАДААД УЛСЫН ШҮҮХЭД МАРГААН ҮҮСЭХЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, МАРГААНЫГ ХЭЛЭЛЦЭЭНИЙ ЗАМААР
ШИЙДВЭРЛЭХ, МАРГААН ҮҮССЭН ТОХИОЛДОЛД
БАРИМТЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь гадаадын арбитр болон гадаад улсын шүүхэд маргаан (цаашид "маргаан" гэх) үүсэхээс урьдчилан сэргийлэх, маргааныг хэлэлцээний замаар шийдвэрлэх, маргааныг шүүх, арбитраар шийдвэрлэх шатанд төрийн байгууллага хоорондын ажлын уялдаа, дотоод зохион байгуулалттай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Монгол Улсын яам, Засгийн газрын агентлаг, төрийн холбогдох бусад байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд (цаашид "Эрх бүхий этгээд" гэх) маргааныг гадаадын арбитр, гадаад улсын шүүхээр шийдвэрлүүлэх заалт бүхий гэрээ байгуулах, талуудын хооронд үүссэн маргааныг хэлэлцээний замаар шийдвэрлэх, шүүх, арбитраар шийдвэрлэх шатанд маргааныг шийдвэрлэх бүх үе шатанд энэхүү журмыг баримтална.

1.3. Энэхүү журмын 1.2-т заасан байгууллага гадаад улсын хуулийн этгээдтэй гэрээ байгуулах, түүнийг хэрэгжүүлэх явцад маргаан үүсгэхээс урьдчилан сэргийлэх, маргаан үүссэн тохиолдолд асуудлыг хэлэлцээний замаар шийдвэрлэхийг эрмэлзэж ажиллана.

Хоёр. Маргаанаас урьдчилан сэргийлэх

2.1. Маргаанаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг гэрээний төсөл боловсруулах болон гомдол гаргасан шатанд эрх бүхий этгээд авч хэрэгжүүлнэ.

2.2. Гэрээгээр зохицуулах асуудлыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллага гэрээний төслийг боловсруулах Ажлын хэсэг байгуулна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд санал, дүгнэлт гаргах байгууллагын төлөөлөл оролцсон тохиолдолд санал, дүгнэлт өгсөнд тооцно.

2.3. Маргааныг гадаадын арбитр, гадаад улсын шүүхээр шийдвэрлүүлэх тухай заалт бүхий хоёр болон олон талт олон улсын гэрээ байгуулах, түүнд нэгдэн ороход уг олон улсын гэрээгээр зохицуулах асуудлыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллага Олон улсын гэрээний тухай хуулийн 9.3-т заасны дагуу холбогдох бусад байгууллагын санал, дүгнэлтийг авна.

2.4. Маргааныг гадаадын арбитр, гадаад улсын шүүхээр шийдвэрлүүлэх тухай заалт бүхий хоёр болон олон талт олон улсын гэрээ байгуулах, түүнд нэгдэн ороход Олон улсын гэрээний тухай хуульд заасан журмын дагуу тухай бүр хууль зүйн болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагуудтай тохиролцоно.